


–

## Кэймёнг Их Сургуулийн Дунсан эмнэлэг

# Эрүүл мэндийн үзлэгийн хөтөлбөр

Эрүүл мэндийн үзлэг нь төрөл бүрийн шинжилгээгээр өвчнийг анхан шатанд нь оношилж амьдралын хэв маягаас үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлсийг эрт үед нь илрүүлж өвчлөлийн явцаас урьдчилан сэргийлэхэд суурилана.

Кэймёнг Их сургуулийн Эрүүл мэндийн үзлэгийн төв нь тав тух, таатай орчинд орчин үеийн шинжилгээний тоног төхөөрөмж, мэргэжлийн эмч, мэргэжилтэнийн зөв оновчтой оношилгоо, өндөр зэрэглэлийн үзлэг үйлчилгээ үзүүлж байна.

Кэймёнг Их сургуулийн Дунсан эмнэлгийн Эрүүл мэндийн үзлэгийн төв нь таны эрүүл мэндийн төлөө насан туршид тань үйлчлэхэд бэлэн байна.

MEDI-CITY DAEGU · MEDICAL KOREA

## Кэймёнг Их сургуулийн Дунсан эмнэлэгийн байршил




42601 Дэгү хот Далсо дүүрэг Далгүбол гудамж 1035
[6 давхар Эрүүл мэндийг дэмжих төв]
Төв утас TEL : 1577-6622

**Эрүүл мэндийг дэмжих төв**
TEL : 053-258-5000 FAX : 053-258-6470
**Цаг товлолт, Зөвлөгөө :**
Ажлын өдөр 08:00~17:00 цаг/
Бямба гариг(2, 4 дэх долоо хоног) 08:00~12:00 цаг

**Олон улсын Эрүүл мэндийн төв**
+82-53-258-4007 (Орос хэл, Монгол хэл) / +82-53-258-4004 (Англи хэл)
**Холбоо барих, зөвлөгөө** : Ажлын өдөр 08:30~17:30 цаг

계명대학교 동산병원
KEIMYUNG UNIVERSITY DONGSAN HOSPITAL

нүүр хуудас VR эмнэлэгээр аялах

# Эрүүл мэндийг дэмжих төв

계명대학교 동산병원
KEIMYUNG UNIVERSITY DONGSAN HOSPITAL

Premium Эрүүл мэндийг дэмжих төвийн Эрүүл мэндийн үзлэгийн хөтөлбөр

# VIP Үзлэг

Тав тух, таатай орчинд орчин үеийн тоног төхөөрөмжтийн тусламжтайгаар зөв оновчтой оношилгоо тогтоож, мэргэжлийн эмч мэргэжилтэний нарийн чадварлаг эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг өндөр зэрэглэлийн нэгдсэн үзлэг хөтөлбөр юм.

## Нэр төрөл

| Шинжилгээний төрөл(Ерөнхий шинжилгээ багтсан) / Байрлангаа шинжилгээ өгөх боломжтой | | |
|---|---|---|
| MRI : Тархи(MRI & MRA),<br>Шилэн хүзүү / Бусэлхий (сонголтоор)<br>PET- CT : Бүтэн бие/ Amyloid(сонголтоор)<br>CT : Титэм артер, Уушиг, Хэвлий<br>ЭХО : Зүрх, Каротид, Бамбайн булчирхай<br>Ходоод & Бүдүүд гэдэсний дуран(унтуулгатай) | Эр | Түрүү булчирхайн ЭХО |
| Ясны сийрэгжилтийн шинжилгээ<br>Дотор өөхлөлтийн шинжилгээ<br>Артериосклероз / судасны хатуурал/ шинжилгээ<br>Стрессийн шинжилгээ | Эм | Хөхний ЭХО<br>Аарцгийн ЭХО<br>Умайн хүзүүний хорт хавдрын шинжилгээ |

**Хорт хавдрын генийн шинжилгээ: Myriad myRisk**

MyRisk бол 35 төрлийн генийн шинжилгээ гээр 8 төрлийн генийн хорт хавдраар өвчлөх эрсдэлийг илрүүлэх шинжилгээ юм.




※ 1:1 онцгойлон зөвлөгөө өгөх
※ Шим тэжээлийн зөвлөгөө
(Мэргэжлийн шим тэжээл судлаач эмч өдөр тутмын хоолны үнэлгээ хийн үйлчлүүлэгчид тохирсон эрүүл хоолоор хангана)

# VIP Эрүүл мэндийн үзлэгийн ахисан тогтолцоо

**VIP Эрүүл мэндийн үзлэгийн**

### Хувь хүнд зориулсан нарийвчилсан хөтөлбөр

Мэргэжилийн координаторын тусламжтайгаар гэр бүлийн өвчний түүх, өөрийн өвчний түүх, эрүүл мэндэд үүсч болзошгүй эрсдэл, үйлчлүүлэгчийн сонирхож буй чиглэл бүхнийг харгалзан өргөн хүрээнд үзлэг хөтөлбөр санал болгоно.

### Fast Track System хэрэгжүүлэх

Мэргэжлийн эмч мэргэжилтэн орчин үеийн төхөөрөмжөөр түргэн шуурхай найдвартай шинжилгээ, оношилгоог хийнэ.

### Тасаг тус бүрийн VIP ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Мэргэжлийн эмчийн үзлэг болон мэс ажилбар хийгдэнэ.

### Шинжилгээний хариу, зөвлөгөө

VIP тасгийн профессор шинжилгээ хийлгэсэн өдөр шинжилгээний хариуг тайлбарлаж зөвлөгөө өгнө.

### Нарийвчилсан давтан үзлэгийн зөвлөгөө болон хяналт

Хэвийн бус илэрц илэрсэн тохиолдолд тухайн тасагт давтан нарийвчилсан зөвлөгөө авч цаашид тогтмол хяналт үзлэгт хамрагдах болно.

# VIP Эрүүл мэндийн үзлэгийн ахисан үйлчилгээ



Мэргэжлийн эмч, мэргэжилтэний зөвлөгөө [VIP үйлчилгээ]



Мэргэжлийн координаторийн үйлчилгээ



Мэргэжлийн шим тэжээлийн багаас таны өдөр тутмын хоолны хэв маягт үнэлгээ хийж, үйлчлүүлэгч тус бүрт тохируулан шим тэжээлийн зөвлөгөө өгнө.
(Хариуцсан тогооч өөрийн биеэр хүрч ирэн үйлчлүүлэгчид тохирсон эрүүл хоолоор үйлчилнэ)